

## ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ

№.../...

2024 оны 2 дүгээр сарын 14 ны-ний өдөр

Хөвсгөл сум

Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх заалт, Засгийн газрын 2015 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн 430, 2016 оны 03 дугаар сарын 28-ны 179 дүгээр тогтоол, Дорноговь аймгийн хөгжлийн мастер төлөвлөгөө, сумын Засаг даргын “Хөгжлийн төлөө хамтдаа” 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрүүдийг үндэслэн:

Нэг талаас Хөвсгөл сумыг төлөөлөлж сумын **Засаг дарга Ч.Энхбаатар**, нөгөө талаас **“Си Өү Эй Эл” ХХК-ийг төлөөлж, гүйцэтгэх захирал Ж.Мөнхбат** нар харилцан тохиролцож энэхүү гэрээг 2024 оны 02 дүгээр сарын 14-ны өдөр Дорноговь аймгийн Хөвсгөл сумын Засаг даргын Тамгын газрын иргэний тамхимд байгуулав.

### НЭГ.НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1 Энэхүү гэрээгээр талууд байгаль орчныг хамгаалах, орон нутгийн хөгжилд дэмжлэг үзүүлэх, уул уурхайн олборлолтын үйл ажиллагааг тогтвортой, хэвийн явуулах чиглэлээр хамтран ажиллах, ажлын уялдаа холбоог сайжруулахтай холбогдсон харилцааг зохицуулна.

1.2 Компани нь тухайн тусгай зөвшөөрлийн талбай орших сумын байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, орон нутгийн иргэдийн амьдрах орчныг сайжруулах, ажлын байр нэмэгдүүлэх, дэд бүтцийг хөгжүүлэхэд бодитой хувь нэмэр оруулах төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд хамтран ажиллана.

1.3 Энэхүү гэрээ нь Монгол Улсын Үндсэн хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Ашигт малтмалын тухай хууль, Газрын тухай хууль, Газрын хэвлийн тухай хууль, Татварын тухай хууль болон бусад хууль, тогтоомжийн хүрээнд явагдана.

### ХОЁР. ХАМРАХ ХҮРЭЭ

2.1 Гэрээний хамрах хүрээ Хөвсгөл сумын нутаг дэвсгэрт хэрэгжиж байгаа “Си Өү Эй Эл” компанийн уурхайн төслийн үйл ажиллагааны хүрээнд орон нутагтай хамтран ажиллах гэрээ гэж ойлгоно.

2.2 Орон нутагт жил бүр хамтын ажиллагааны гэрээний хүрээнд техник тоног төхөөрөмжийн дэмжлэгээс гадна 150,0 сая төгрөгийн санхүүжилтийг төвлөрүүлнэ.

2.3 Мөнгөн санхүүжилт болох 75.0 сая төгрөгийг 2024 оны 03-р сарын 31-ний дотор үлдэгдэл санхүүжилтыг үе шаттайгаар 2024 оны 06 дугаар сарын 30-ний дотор 5372122780 (гуа тээг хайрхан уул ) дансанд төвлөрүүлсэн байна.

2.4 Хамтран ажиллах гэрээг хэрэгжүүлэхэд талууд дараах үндсэн чиглэлүүдийг баримтална. **Үүнд:**

2.4.1 Дэд бүтэц, бүтээн байгуулалтыг сайжруулах;

2.4.2 Байгаль орчныг хамгаалах;

2.4.3 Ажлын байрыг нэмэгдүүлэх;

2.4.4 Орон нутгийн жижиг дунд бизнесийн үйл ажиллагааг дэмжих;

2.4.5 Соёлын өвийг хамгаалах;

2.4.6 Иргэдийг соён гэгээрүүлэх, сургалт сурталчилгаа зохион байгуулах, гадаад дотоодод туршлага солилцоход санхүүгийн дэмжлэг үзүүлж хамтран ажиллах;

2.4.7 Сумын харьяат иргэдийг нарийн мэргэжлийн үзлэг оношилгоонд хамрагдах, гадаад улс оронд эмчилгээнд явахад санхүүгийн дэмжлэг үзүүлэх;

2.4.8 Тив, дэлхий, улс аймгийн хэмжээнд амжилт гарган аймаг, сум орон нутгийн нэрийг гаргасан иргэдийг шагнаж, урамшуулах, хүндэтгэл үзүүлэх;

2.4.9 Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн тэгш ой баяр, тэмдэглэлт баяр ёслол бүх нийтийг хамарсан арга хэмжээг тэмдэглэн өнгөрүүлэхэд санхүүжилт шийдвэрлэх;

2.4.10 Гамшгаас хамгаалах бэлэн байдлыг хангах, сургалт сурталчилгаа, техник тоног төхөөрөмж, хувцас хэрэгслийг бэлтгэхэд дэмжлэг үзүүлж хамтран ажиллана.

2.4.11 Урьдчилан тооцох боломжгүй, цаг үеийн шинжтэй зарим асуудлыг шийдвэрлэхэд шаардагдах зардалд дэмжлэг үзүүлж хамтран ажиллах;

2.4.12 Төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой байгууллагууд, иргэдээс тавьсан санал хүсэлтийг шийдвэрлэх;

2.4.13 Компанийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авахтай холбогдсон мэдээллийг иргэдэд ил тод, нээлттэй хэлбэрээр хүргэх ажлыг зохион байгуулах;

2.4.14 Компанийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авахтай холбогдсон шалгуур үзүүлэлт, тавигдах шаардлагуудыг орон нутгийн бизнес эрхлэгч, иргэдэд танилцуулахад хамтран ажиллах.

2.4.15 Нутгийн захиргааны байгууллага нь компанийн үйл ажиллагаанд Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу дэмжлэг үзүүлж, хамтран ажиллана.

2.4.16 Талууд хамтран энэхүү гэрээний 2.2.1-2.2.3-т заасан асуудлаар олон нийтийн хэлэлцүүлэг явуулж болно.

2.4.17 Компани нь тусгай мэргэжил шаардахгүй ажлын байр зарлагдсан тохиолдолд нэн тэргүүнд орон нутгийн иргэдийг авч ажиллуулах.

2.4.18 Компани нь төслийн үйл ажиллагааны нөлөөнд өртсөн орон нутгийн эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулах үүднээс орон нутгийн бизнесийг дэмжих төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх талаар хамтран ажиллана.

**ГУРАВ. ЗАСАГ ДАРГЫН ЭРХ, ҮҮРЭГ**

3.1 Ашигт малтмалын олборлолт, боловсруулах үйлдвэрлэл явуулах хугацаанд тус компанид хууль тогтоомжийн хүрээнд төрийн үйлчилгээ үзүүлж, хяналт тавьж ажиллана.

3.2 Аж ахуйн нэгж, байгууллагын захиалгаар мэргэшсэн ажилтан бэлдэхэд дэмжлэг үзүүлнэ.

3.3 Компанийг ашигт малтмал олборлох, үйлдвэр уурхай байгуулах, цаашид үйл ажиллагаагаа тогтвортой, хэвийн явуулахад орон нутгийн холбогдох байгууллага, албан тушаалтны зүгээс шаардагдах үйлчилгээг шуурхай үзүүлж, дэмжлэг үзүүлнэ.

3.4 Сумын хөгжилд оруулсан хөрөнгийн зарцуулалтыг жил бүр тооцож, ил тод мэдээлэл нь.

3.5 Цөлжилтийг бууруулах, сумын ногоон байгууламжийг нэмэгдүүлэхэд хамтран ажиллана.

3.6 Усны тоолууржуулалт баталгаажилтыг хийж хяналт тавина.

3.7 Уул уурхайн бүтээгдэхүүн тээвэрлэх авто тээврийн замын маршрут хяналт тавина.

3.8 Компанийн зарласан ажлын байрны мэдээллийг иргэдэд ил тод, нээлттэй хэлбэрээр хүргэх ажлыг зохион байгуулах, орон нутгийн телевиз, радио, сонингоор түгээх.

3.9 Төслийн бүтээн байгуулалт, туршилт тохиргоо, зүгшрүүлэлтийн ажил, зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэрээгээр зайлшгүй ажиллах шаардлагатай гадаад, дотоод ажиллагсдын хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх.

### **ДӨРӨВ. КОМПАНИЙН ЭРХ, ҮҮРЭГ**

4.1 Ажиллагсдыг гэнэтийн ослын болон эрүүл мэндийн даатгалд бүрэн хамруулна.

4.2 Гамшиг, осол, гал түймэр гарсан үед сайн дурын үндсэн дээр тухайн сум, орон нутагт техник, тоног төхөөрөмж, ажиллах хүчний болон шаардлагатай бусад туслалцаа үзүүлнэ.

4.3 Уул уурхайн болон боловсруулах үйлдвэрийн үйл ажиллагааг сум, орон нутгийн иргэдэд сурталчилна.

4.4 Уул уурхайн бүтээгдэхүүн тээвэрлэх авто тээврийн замын маршрутыг аймгийн Засаг даргаар батлуулж, замыг хайрган хучилттай болгон тогтмол засвар арчилгааг хийж, бүтээгдэхүүн тээврийн авто машинуудыг бүрэн хучлагатай болгоно.

4.5 Машины тоо, хүчин чадал, авто тээврийн стандарт журмын шаардлагыг хангаж байгаа тохиолдолд ашигт малтмалын бүтээгдэхүүний тээврийг орон нутгийн жолооч, аж ахуйн нэгжээр хийлгэнэ.

## ЗУРГАА. ГЭРЭЭНИЙ ХАРИУЦЛАГА

6.1 Талууд үйл ажиллагаандаа Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийг удирдлага болгоно.

6.2 Энэхүү гэрээг биелүүлэхэд хоёр тал санаачлан гаргаж ажиллана.

6.3 Гэрээгээр хүлээсэн эрх, үүргээ гуравдагч этгээдэд шилжүүлэхийг хориглоно.

6.4 Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ. Энэхүү гэрээ нь компанийг хуулиар хүлээсэн бусад үүргээс чөлөөлөх үндэслэл болохгүй.

## ДОЛОО. ГЭРЭЭ ХҮЧИН ТӨГӨЛДӨР БОЛОХ

7.1 Энэхүү гэрээ нь Талууд гарын үсэг зурсан өдрөөс 1 жилийн хугацаанд хүчин төгөлдөр үйлчилнэ.

7.2 Давагдашгүй хүчин зүйлсийн улмаас гэрээг хугацаанаас өмнө дуусгавар болгож болно.

7.3 Энэхүү гэрээг монгол хэл дээр 2 (хоёр) хувь үйлдэнэ. Шаардлагатай бол Монгол, Англи хэл дээр үйлдэж болох бөгөөд зөрүү гарвал Монгол эхийг баримтална.

## НАЙМ. МАРГААН ШИЙДВЭРЛЭХ

8.1 Гэрээг тайлбарлах болон гэрээний хэрэгжилттэй холбоотой маргаан, зөрчлийг тухай бүр, эв зүйгээр шийдвэрлэхийг эрхэмлэнэ.

8.2 Хэрэв маргаантай асуудлаар талууд тохиролцоонд хүрээгүй тохиолдолд Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу Монгол Улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

## ЕС. БУСАД

9.1 Талууд гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулсан өдрөөс гэрээ хүчин төгөлдөр үйлчилнэ.

9.2 Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр гэрээнд зөвхөн бичгээр нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

9.3 Хэрэв гэрээнд ямар нэгэн өөрчлөлт оруулах шаардлага гарвал нөгөө талдаа 30 хоногийн өмнө харилцан бичгээр мэдэгдэнэ. Оруулсан нэмэлт өөрчлөлтийг гэрээнд хавсаргаснаар нэмэлт, өөрчлөлт нь энэхүү гэрээний нэгэн адил хүчинтэй байх бөгөөд гэрээний салшгүй хэсэг болно.

## ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:


ДОРНОГОВЬ АЙМГИЙН ХӨВСГӨЛ СУМЫГ "СИ ӨҮ ЭЙ ЭЛ" ХХК-ИЙГ ТӨЛӨӨЛЖ:

ТӨЛӨӨЛЖ:  
ЗАСАГ АРГА  
Ж.МӨНХБААТАР /

Утас:

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  
Ж.МӨНХБАТ /

Утас:



4.6 Сумын дэд бүтцийн асуудлыг шийдвэрлэхэд хоёр тал идэвх санаачлага гарган хамтран ажиллана.

4.7 Компани нь сумын төвийн нийтийн зориулалттай хог хаягдлын менежментийг үе шаттайгаар сайжруулахад дэмжлэг үзүүлж ажиллана.

4.8 Техникийн болон биологийн нөхөн сэргээлтийг стандартын дагуу чанартай хийж гүйцэтгэнэ орон нутагт хүлээлгэн өгнө.

4.9 Аймаг болон сумдын төрийн байгууллагууд, нутгийн иргэдийг уурхайн нөхөн сэргээлтийн үйл ажиллагаатай танилцуулах ажлыг орон нутгийн захиргааны байгууллагатай хамтран зохион байгуулна.

4.10 Уурхай, үйлдвэрлэлд ашиглаж байгаа худгийг бүрэн тоолууржуулах, усны тоолуурын батгаажуултыг сар бүр хийлгэх, төлбөрийг тогтоосон хугацаанд төлөх.

4.11 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгагддаг агаар, ус, хөрсний шинжилгээг Дорноговь аймаг дахь лабораториудаар жилд 1-ээс доошгүй удаа хийлгэнэ.

4.12 Ашиглалт, олборлолтын ажлыг ТЭЗҮ, уулын ажлын төлөвлөгөөний дагуу ажиллана.

4.13 Хог хаягдалын гэрээ, Түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглуулах гэрээг жил бүр шинэчлэн байгуулах тайлагнах.

4.14 Уурхайд ажиллах хүчний 15 хувийг сум, орон нутгаас авч ажиллуулах

4.15 Компани нь орон нутгийн хөдөлмөрийн хэлтэстэй хамтран ажиллах бөгөөд шаардлагатай ажлын байр, тавигдах шаардлагыг тухай бүр олон нийтэд зарлана.

4.16 Компани нь төслийн үйл ажиллагаа явуулж буй сумдын сургууль, цэцэрлэгийг сайжруулахад дэмжлэг үзүүлж, Дорноговь аймаг болон сумдтай хамтран ажиллана.

4.17 Орон нутгийн уламжлалт ариун дагшин газар буюу сүсэг бишрэлийн хувьд ач холбогдолтой уул, овоо, рашаан ус зэрэг байгалийн онцлог тогтоцуудыг орон нутагтай хамтран хамгаалах, орчны тохижилтыг сайжруулах арга хэмжээг дэмжиж ажиллана.

### **ТАВ. ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ**

5.1 Гэрээний ил тод байдлыг хангах зорилгоор тухайн орон нутгийн иргэдэд гэрээ байгуулсан талаар мэдээлэх бөгөөд гэрээг орон нутгийн болон компанийн цахим хуудсанд байршуулна.

5.2 Хамтын ажиллагааны хороо нь Гэрээний биелэлтийг жилд нэг удаа дүгнэх ба тухайн сумын Засаг дарга гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж болно.

5.3 Талууд гэрээний тухайн жилийн биелэлтийн тайланг дараа оны 01 дугаар сарын 15-ны өдрийн дотор орон нутаг болон геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

4.6 Сумын дэд бүтцийн асуудлыг шийдвэрлэхэд хоёр тал идэвх санаачлага гарган хамтран ажиллана.

4.7 Компани нь сумын төвийн нийтийн зориулалттай хог хаягдлын менежментийг үе шаттайгаар сайжруулахад дэмжлэг үзүүлж ажиллана.

4.8 Техникийн болон биологийн нөхөн сэргээлтийг стандартын дагуу чанартай хийж гүйцэтгэнэ орон нутагт хүлээлгэн өгнө.

4.9 Аймаг болон сумдын төрийн байгууллагууд, нутгийн иргэдийг уурхайн нөхөн сэргээлтийн үйл ажиллагаатай танилцуулах ажлыг орон нутгийн захиргааны байгууллагатай хамтран зохион байгуулна.

4.10 Уурхай, үйлдвэрлэлд ашиглаж байгаа худгийг бүрэн тоолууржуулах, усны тоолуурын батгаажуултыг сар бүр хийлгэх, төлбөрийг тогтоосон хугацаанд төлөх.

4.11 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгагддаг агаар, ус, хөрсний шинжилгээг Дорноговь аймаг дахь лабораториудаар жилд 1-ээс доошгүй удаа хийлгэнэ.

4.12 Ашиглалт, олборлолтын ажлыг ТЭЗҮ, уулын ажлын төлөвлөгөөний дагуу ажиллана.

4.13 Хог хаягдалын гэрээ, Түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглуулах гэрээг жил бүр шинэчлэн байгуулах тайлагнах.

4.14 Уурхайд ажиллах хүчний 15 хувийг сум, орон нутгаас авч ажиллуулах

4.15 Компани нь орон нутгийн хөдөлмөрийн хэлтэстэй хамтран ажиллах бөгөөд шаардлагатай ажлын байр, тавигдах шаардлагыг тухай бүр олон нийтэд зарлана.

4.16 Компани нь төслийн үйл ажиллагаа явуулж буй сумдын сургууль, цэцэрлэгийг сайжруулахад дэмжлэг үзүүлж, Дорноговь аймаг болон сумдтай хамтран ажиллана.

4.17 Орон нутгийн уламжлалт ариун дагшин газар буюу сүсэг бишрэлийн хувьд ач холбогдолтой уул, овоо, рашаан ус зэрэг байгалийн онцлог тогтоцуудыг орон нутагтай хамтран хамгаалах, орчны тохижилтыг сайжруулах арга хэмжээг дэмжиж ажиллана.

#### **ТАВ. ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ**

5.1 Гэрээний ил тод байдлыг хангах зорилгоор тухайн орон нутгийн иргэдэд гэрээ байгуулсан талаар мэдээлэх бөгөөд гэрээг орон нутгийн болон компанийн цахим хуудсанд байршуулна.

5.2 Хамтын ажиллагааны хороо нь Гэрээний биелэлтийг жилд нэг удаа дүгнэх ба тухайн сумын Засаг дарга гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж болно.

5.3 Талууд гэрээний тухайн жилийн биелэлтийн тайланг дараа оны 01 дугаар сарын 15-ны өдрийн дотор орон нутаг болон геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.